

ДОРНОД АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ 8 ДУГААР САРЫН МЭДЭЭ

ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААН:

Хуралдаан 2020 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 14:10 цагт аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдааны танхимд хуралдав. Гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай /Зарим сумын төвийн нэгдсэн халаалтын зуух, дулаан хангамжийн шугам сүлжээ барих төслийг концессын барих, өмчлөх-ашиглах төрлөөр хэрэгжүүлэх/, Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлд санал өгөх тухай асуудлуудыг хэлэлцэн батлав.

БУСАД АЖЛЫН ХҮРЭЭНД:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх “Төр, хувийн хэвшлийн зөвлөл”, Зүүн Бүсийн Эдийн Засгийн Хүртээмжтэй Өсөлтийг Хангахад Хувийн Хэвшлийн Оролцоог Дэмжих нь төсөлтэй хамтран зохион байгуулсан "Хөдөө аж ахуйн бизнес" сургалтанд ХАА-н бизнес эрхлэгчид, хувиараа бизнес эрхлэгчдийн төлөөлөл оролцлоо.

Сургалтын эхэнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Л.Хишигтогтох оролцож мэндчилгээ дэвшүүлж, оролцогчдод амжилт хүслээ.

Сургалтыг Зүүн Бүсийн Хөдөө Аж Ахуйн Бизнес (орон нутгийн үйлдвэрлэл ба эрэлт), Мах, махан бүтээгдэхүүн, сүүн бүтээгдэхүүний эрүүл ахуйн стандарт, ХАА-н бизнесийн нэмүү өртгийн сүлжээний зураглал, Бизнесээ өргөжүүлэх боломжууд зэрэг сэдвээр зохион байгуулж байна.

Хоёр. ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:

Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газар, MERIT төслийн хамтарсан хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан "Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт" сэдэвт сургалтад 2020 оны 08 дугаар сарын 03-07-ны өдрүүдэд, Монгол Улсын Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулсан “Оролцооны хяналт шинжилгээ, үнэлгээ болон олон нийтийн мэдээлэл харилцааны чадавх бэхжүүлэх” Зүүн бүсийн сургалтад 2020 оны 08 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд тус тус хамрагдсан.

ГУРАВ. ТӨСВИЙН ОРЛОГЫН ТАЛААР:

Орон нутгийн нийторлого 55106.1 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 52013.6 сая төгрөг, үүнээс татварын орлого 13205.2 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэл нь 12503.2 сая төгрөгт хүрч 702.0 сая, татварын бус орлого 41900,9 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэл нь 39510,5 сая төгрөгт хүрч 2390,4 сая тус тус төгрөгөөр тасарлаа.

Орон нутгийн төсвийн нийт орлого

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө /өссөндүнгээр/	Гүйцэтгэл /өссөндүнгээр/	Өөрчлөлт	
			Тоо	Хувь
002 ОРОН НУТГИЙН ОРЛОГО	55,106,085,800.00	52,013,632,761.82	(3,092,453,038.18)	94.39
003 ТАТВАРЫН ОРЛОГО	13,205,196,700.00	12,503,165,274.59	(702,031,425.41)	94.68
004 Орлогын албан татвар	7,722,580,000.00	8,173,371,097.26	450,791,097.26	105.84
016 Хөрөнгийн албан татвар	597,005,300.00	743,919,140.15	146,913,840.15	124.61
021 Бусад татвар, төлбөр, хураамж	4,665,495,000.00	3,572,290,297.34	(1,093,204,702.66)	76.57
041 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	41,900,889,100.00	39,510,467,487.23	(2,390,421,612.77)	94.30
042 Нийтлэг татварын бус орлого	2,616,160,000.00	2,447,332,702.23	(168,827,297.77)	93.55
049 Хөрөнгийн орлого	0.00	46,163,760.00	46,163,760.00	
056 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	29,577,115,100.00	28,429,195,765.00	(1,147,919,335.00)	96.1
058 Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	25,066,528,700.00	25,066,528,700.00	-	100.0
059 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	4,510,586,400.00	3,362,667,065.00	(1,147,919,335.00)	74.6

ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТАЛААР:

Аймгийн төсвийн нийт зарлага 59663,8 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 49009,7 сая төгрөгийн гарсан гүйцэтгэлийг бүрэн санхүүжүүлсэн.

Нийт төсвийн зарлагын

- ✓ Цалин, нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын хураамжинд 58,5%
- ✓ Тогтмол зардалд 18,3%
- ✓ Бараа үйлчилгээний бусад зардалд 9,8%
- ✓ Хөрөнгийн зардалд 13,4% байна.

Аймгийн төсвөөс сумдад олгох санхүүгийн дэмжлэгт 5248,3 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр 25066,5 сая төгрөгийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн санхүүжүүллээ.

Орон нутгийн төсвийн нийт зарлага

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө /өссөндүнгээр/	Гүйцэтгэл /өссөн дүнгээр/	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	59,663,789,500.00	49,009,684,269.78	(10,654,105,230.22)	82.1
Цалинхөлсболоннэмэгдэлурамшил	25,557,141,400.00	22,926,919,880.25	(2,630,221,519.75)	89.7
Ажиллолгогчооснийгмийндаатгалдтө лөхшимтгэл	3,340,069,400.00	2,874,731,247.14	(465,338,152.86)	86.1
Бараа үйлчилгээний бусад зардал	4,056,093,500.00	2,455,011,122.90	(1,601,082,377.10)	60.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,638,990,200.00	1,091,051,894.31	(547,938,305.69)	66.6
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,593,169,200.00	8,034,110,011.80	(4,559,059,188.20)	63.8

ЖИЧ: Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн дэлгэрэнгүй мэдээлэлийг Аймгийн ЗДТГ-ын № 15 тоот өрөө, www.dornod.gov.mn вэб сайт, 70583034, 70582372 дугаарын утсаар авч болно

Дөрөв. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс аймгийн Засаг даргын захирамжийн биелэлтэд тогтмол хяналт тавьж ажилласан.

“Жаст ойл” ХХК-ийн нэхэмжлэлтэй, аймгийн Засаг дарга хариуцагчтай, аймгийн Засаг даргын 2020 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн А/418 дугаар захирамжийг хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлагатай захиргааны хэрэгт хариу тайлбарыг бичиж шүүхэд хүргүүлсэн.

Аймгийн Дашбалбар сумын Ардчилсан намын нэхэмжлэлтэй, аймгийн Сонгуулийн хороо хариуцагчтай, аймгийн Сонгуулийн хорооны 2020 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 03 дугаар тогтоолыг хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлагатай захиргааны хэрэгт хариу тайлбар гаргасан.

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 5528 дугаартай шүүгчийн захирамжийг бүхэлд эс зөвшөөрч Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасан.

Дорнод аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 13 дугаар шийдвэрийг нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч зүгээс эс зөвшөөрч, 2020 оны 07 дугаар сарын 22-ны өдөр давж заалдах журмаар гаргасан гомдолтой танилцаад, холбогдох хариу тайлбарыг шүүхэд хүргүүлсэн.

Капитал банкны эрх хүлээн авагчийн нэхэмжлэлтэй, аймгийн Засаг дарга хариуцагчтай, Аймгийн Засаг даргын 2019 оны А/482 дугаар захирамжийг хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлагатай захиргааны хэрэгт Монгол Улсын дээд шүүхэд холбогдох гомдлыг гаргасан.

Аймгийн 2020 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих “Аймгийн Цагдаагийн газрын Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх тасагт автомашин хүлээлгэн өгөх” ажлыг ажлын даалгавар, техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авч, зохион байгуулаад байна.

“Их монгол барилга” ХХК-д Засаг даргын 2020 оны А/415 дугаар захирамжийн Матад суманд холбогдох хэсгийг хүчингүй болгох тухай шийдвэрийг 2020 оны 08 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон гаргах болсон талаарх мэдэгдлийг хүргүүлсэн.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж нийт 8 өргөдөл ирүүлснээс 6 өргөдөл гомдлыг шийдвэрлэн холбогдох хариуг иргэдэд өгч ажилласан. аймгийн Засаг даргад хандан мөнгөн тусламж хүссэн 1 иргэнд 350.000 төгрөгийн буцалтгүй тусламжийг олгуулах ажлыг зохион байгуулаад байна.

Тав. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Нэг. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газар

Улаанбаатар хот, “Чингисийн хүрээ” жуулчны баазад зохион байгуулагдсан Үндэсний их сурын Улсын аварга шалгаруулах багийн харвааны тэмцээнд 21 аймаг, 9 дүүргийн 57 багууд оролцсноос Дорнод аймгийн 1 дүгээр баг шигшээ 16-д, 2 дугаар баг шигшээ 32-т шалгарч, багийн дүнгээр шагналт 5 дугаар байр эзэлсэн бол цуваа харвааны төрөлд нийт 1000 гаруй харваачид оролцсон байна.

Монголын Волейболын Холбооны Ахмад волейболчдын улсын аварга шалгаруулах тэмцээн Улаанбаатар хотноо болж эрэгтэй 16, эмэгтэй 12 багийн нийти 336 тамирчид оролцож, эмэгтэй 40-49 насанд Ч.Мөнхтулга ахлагчтай “Дорнод” багийн тамирчид хүрэл медаль хүртсэн. Мөн эмэгтэй “Шилдэг хамгаалагч”-аар “Дорнод” багийн тамирчин, Олон Улсын хэмжээний мастер Г.Баярмаа шалгарсан.

Монголын Хөл Бөмбөгийн Холбооны “Үндэсний Нэгдүгээр Лиг 2020” тэмцээнд Л.Наранбаатар ахлах дасгалжуулагчтай “Эвт Хөх Чоно” баг амжилттай оролцож байна.

Аймаг орон нутагт зохион байгуулсан биеийн тамир, спортын арга хэмжээ:

Дорнод аймгийн Бадминтоны холбоо, Хэнтий аймгийн Бадминтоны Холбоо хамтран нөхөрсөг тэмцээн зохион байгуулж, нийт 26 тамирчин хамрагдав.

Биеийн тамир, спортын газарт спортын 6 дугуйлан цагийн хуваарийн дагуу хичээллэж байна. Мөн Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнд: Тамирчдын биеийн халууныг үзэн зааланд оруулах, гарыг ариутгах, нэг удаагийн бэлтгэлд 25-аас ихгүй тамирчдыг хамруулах, заал болон бэлтгэлийн тоног төхөөрөмжийг ариутгалын бодисоор ариутган цэвэрлэж байна.

Сургалт, семинар:

Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооноос Биеийн тамир, спортын салбарын бүтэц зохион байгуулалт, удирдлага өөрчлөгдөн хөгжлийн бодлогын шинжилгээ хийх, хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хувилбар боловсруулах, эдийн засаг, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн бодлогыг төлөвлөх, төсөв боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, төрийн захиргааны болон хүний нөөцийн манлайллыг хангах, статистик мэдээлэл, мэдээллийн сан бүрдүүлэх талаар 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн биеийн тамир, спортын байгууллагуудын удирдлага болон албан хаагчдын дунд онлайн сургалтыг зохион байгуулж, Дорнод аймгаас 10 албан хаагчид хамрагдав.

Монголын Талбайн Теннис Холбооноос зохион байгуулсан дасгалжуулагчийн сургалт байгууллагын 1 дасгалжуулагч хамрагдав.

Хоёр. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсрол, соёл, урлагийн газар

2020-2021 оны хичээлийн жилийн бэлтгэл ажлыг хангах, цэцэрлэг, сургуулийн орчинд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах, энэ чиглэлээр гарсан Улсын Онцгой комисс, Засгийн газар, БШУЯ-ны сайд, аймгийн Засаг даргын баталсан тушаал, шийдвэр, дүрэм, журмыг танилцуулах, орон нутгийн онцлогт тулгуурлан бэлтгэл ажлын зохион байгуулалтыг хангахад чиглэл, зөвлөмжөөр хангах зорилгоор “2020-2021 оны хичээлийн жилийн бэлтгэл ажил, анхаарах асуудал” сэдэвт сургалт семинарыг 2020 оны 8 дугаар сарын 19, 20-ны өдрүүдэд зохион байгуулав.

Сургалтад аймгийн ерөнхий боловсролын сургуулийн захирал, Хэрлэн сумын ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер, цэцэрлэгийн эрхлэгч, аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсрол, соёл урлагийн газрын мэргэжилтэн, мэргэжлийн сургууль, коллежийн 105 хүн хамрагдсан. Энэ үеэр 2020-2021 оны хичээлийн жилийн бэлтгэл ажлыг хангах, онцгой байдлын үеийн тушаал шийдвэр, сургалтын хөтөлбөрийн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга зүйн дэмжлэг үзүүлж, аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газраас холбогдох мэдээллүүдийг танилцуулж, заавар, зөвлөмж өгөв.

Боловсролын байгууллагуудын дижитал шилжилтийг нэмэгдүүлэх, “Сургуулийн үйл ажиллагааг цахимаар удирдан зохион байгуулах Амжилт 2.0 цогц систем”-ийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж, “Амжилт Дотком” төслөөс “Цахим шилжилтийн асуудал” сэдвээр сургалт зохион байгуулсан.

“Амжилт 2.0 цогц систем”-ийг Хэрлэн сумын ерөнхий боловсролын 12 дугаар сургууль, Дорнод ахлах сургууль, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд хэрэгжүүлэхээр болсон.

Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйд дэмжлэг үзүүлэх онлайн сургалтыг 10 мэргэжлээр 438 багш нарт хийсэн.

Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангид элсэгчдийн 70 хувийг цахимаар бүртгэсэн.

2020-2021 оны хичээлийн жилийн бэлтгэл ажлыг хангах, цэцэрлэг, сургуулийн орчинд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах, энэ чиглэлээр гарсан Улсын Онцгой комисс, Засгийн газар, БШУЯ-ны сайд, аймгийн Засаг даргын баталсан тушаал, шийдвэр, дүрэм журмын хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн төвийн сургууль, цэцэрлэг, Баян-Уул, Цагаан-Овоо, Чулуунхороот сумдад очиж ажилласан.

Гурав. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар

“Өргөдөл, гомдол”-ын шийдвэрлэлтийн мэдээлэл:

Тайлант сард хүүхэд, гэр бүлийн эрх зөрчигдсөн асуудлаар өргөдөл, гомдол, хүсэлт, хүүхдийн тусламжийн 108 утсаар нийт 10 дуудлагыг хүлээн авч хуулийн дагуу хамгааллын хариу үйлчилгээг үзүүлж ажилласан бөгөөд шийдвэрлэлт 70 хувьтай байна. “Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх өрөө” энэ сард нийт 16 хүүхэд, насанд хүрэгчид давтамжтай зөвлөгөө үйлчилгээ авсан. “Нэг цэгийн үйлчилгээний төв”-д энэ сард гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 1 хүүхдийг хүлээн авч, 2-30 хоногийн хугацаатай байршуулж, аюулгүй байдалд хяналт тавин эрүүл мэнд, сэтгэлзүй, хууль эрх зүйн болон холбон зуучлах, хамгааллын үйлчилгээг үзүүлэн харъяа хамтарсан багт шилжүүлж, үйлчлүүлэгчтэй ажиллах кейс төлөвлөгөө боловсруулан хариу үйлчилгээ үзүүлж байна. Мөн уг төвөөр үйлчлүүлж байсан 9, 14 настай 2 хүүхдийг “Өнөр бүл” улсын асрамжийн төвд хүмүүжүүлэхээр хүргэсэн.

Гэр бүлийн маргаантай асуудлаар 2 иргэнд сэтгэл зүйн зөвлөгөө өгч, хүүхдийн асран хамгаалалтай холбоотой асуудлаар 2 хүүхэд, 4 иргэнд сэтгэл зүйн оношлогоо хийж Шүүх байгууллагаас ирүүлсэн гэр бүл цуцлалт, хүүхдийн асран хамгаалал тогтоохтой холбоотой шинжээчийн дүгнэлт гаргах асуудлаар Хэрлэн, Цагаан-Овоо сумдад ажилласан. Үрчлэлтийн дүгнэлт хийгдэхээр ирүүлсэн 4 өрхийн нөхцөл

байдлыг судлан дүгнэлтийг гарган Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

Мөн насанд хүрээгүй хохирогч хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр 4 шүүх хуралд оролцож, хүүхдийн эрхийг хамгаалсан.

Мэдлэг чадвараа дээшлүүлэх чиглэлээр:

Аймгийн Засаг даргын Тамгын газраас Мерит төсөлтэй хамтран Сүхбаатар аймагт зохион байгуулсан “Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт” сэдэвт 5 өдрийн сургалтад 2 мэргэжилтэн хамрагдсан. Уг сургалтын үр дүнг байгууллагын албан хаагчдад түгээн дэлгэрүүлэх зорилгоор дотоод сургалтын төлөвлөлтөд оруулаад байна. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас зохион байгуулагдсан “Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” 3 өдрийн сургалтад 1 мэргэжилтэн хамрагдаж, чадавхжсан.

Залуучуудын хөгжил оролцооны чиглэлээр:

Залуучууд хөгжлийн төвөөс “Амьдрах ухааны чадвар олгох 12 модуль сургалт”-ыг цувралаар өсвөр үе, залуучуудад тогтмол зохион байгуулж байна. Ахуйн үйлчилгээнд ажиллаж, хорих ял эдэлж байгаа, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүүхдүүд, аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Цагдаагийн газрын эрүүлжүүлэх саатуулах байрны баривчлах байранд хүмүүжиж байгаа нийт 122 иргэнд “Жендэрийн тухай ойлголт”, “Харилцаа хандлага”, “Өөртөө итгэх итгэл”, “Сэтгэлийн хөдөлгөөнөө хянах”, “Стрессийг зохицуулах нь”, “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга”, “Холбоо тогтоох чадвар” сэдвүүдээр сургалтыг зохион байгуулав. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Цагдаагийн газартай хамтран “Хорт зуршилгүй залуу” нөлөөллийн ажлын хүрээнд Хэрлэн сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй бар ресторан, караоке, зочид буудал, 8 нэрийн хүнсний дэлгүүр гэх мэт 30 гаруй аж ахуй нэгж, байгууллагуудад зөвлөмжийг хүргэхээс гадна насанд хүрээгүй хүүхдэд архи согтууруулах ундаа борлуулахгүй байх, хөдөлмөр эрхлүүлэхгүй байх шаардлагыг хүргэж ажилласан.

Мөн бусдынхаа болон нийгмийн сайн сайхны төлөөх үйлст сайн дураараа нэгдэн, өөрийн хувь нэмрээ оруулан ажиллаж сайн дурын үйл ажиллагааг орон нутагтаа түгээн дэлгэрүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулан ажиллаж, 12 дугаар анги төгссөн сайн дурын клубийн гишүүдийг хүлээн авч уулзан, сертификат гардуулав.

Дөрөв. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг

Нийгмийн даатгалын хэлтэс

Нэг. Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлтийн талаар:

Нийгмийн даатгалын санд 2020 оны 08 дугаар сард 2163094.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 1830071.5 мянган төгрөг төвлөрүүлэн төлөвлөгөөг 84,6 хувиар биелүүлсэн. 2020 оны 08 дугаар сарын мэдээгээр нийгмийн даатгалын сангийн орлогын биелэлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1

Нийгмийг даатгалын сангийн орлого /мянган төгрөг/

д/д	Төрөл	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
1	Тэтгэврийн даатгалын санд	703878,6	1175737,65	167,0
2	Тэтгэмжийн даатгалын санд	65018,7	132067,15	203,1
3	Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын санд	49217,7	128320,91	260,7
4	Ажилгүйдлийн даатгалын санд	10324,5	28436,7	275,4
5	Эрүүл мэндийн даатгалын сан	1334654,5	365509.13	232,0
	Нийт	2163094.0	1830071.5	84,6

2020 оны 08 дугаар сард нийт 650 ажил олгогч байгууллагын 4755 даатгуулагчийн 3352823,4 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлээс (Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээс бусад) чөлөөлсөн.

Түүнчлэн 3940 сайн дурын даатгуулагчдын 836041.5 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлээс тус тус чөлөөлсөн байна.

Хоёр. Тэтгэвэр тогтоолт, олголтын талаар:

Аймгийн хэмжээнд 2020 оны 08 дугаар сард шинээр нийт 103 иргэнд тэтгэвэр тогтоосон. Үүнд: Өндөр насны тэтгэвэр 77, (малчин 13, хүүхдээр 22, хүнд нөхцлөөр 4, цэргийн алба хаасны тэтгэвэр 2, хэвийн өндөр насны тэтгэвэр 36). Мөн тахир дутуугийн тэтгэвэр 21, Тэжээгч алдсны тэтгэвэр 5 тус тус тогтоов.

Түүнчлэн 2020 оны 06 дугаар сард нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалын сангаас нийт: Өндөр насны 8900, Тахир дутуу 2765, Тэжээгчээ алдсан 610, Цэргийн тэтгэвэр 599, нийт 12874 тэтгэвэр авагчдад нийт 4996284,03 мянган төгрөгийн тэтгэвэр олгосон.

Гурав. Тэтгэмж олголтын талаар:

Тэтгэмжийн даатгалын сангаас: Хөдөлмөрийн чадвар түр алдсны тэтгэмж 151, жирэмсэн амаржсны тэтгэмж 139, Оршуулгын тэтгэмж 29 даатгуулагчид нийт 511936,8 мянган төгрөгийн тэтгэмжийг тус тус олгов.

Дөрөв. Ажилгүйдлийн тэтгэмж олголтын талаар:

Аймгийн хэмжээнд 2020 оны 8 дугаар сард нийт 81 даатгуулагчдад 40,8 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг бодож олгов. Энэ нь өмнөх сартай харьцуулахад 6 даатгуулагчийн 5,0 сая төгрөгөөр ажилгүйдлийн даатгалын зардал буурсан үзүүлэлттэй байна.

Тав. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн зардал:

Нийт 94 тэтгэвэр авагчдад 140526,7 мянган төгрөгийн тэтгэвэр олгосон. Рашаан сувиллын зардал 1 даатгуулагчид 332,0 мянган төгрөгийг олгосон.

Зургаа. Нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлагын чиглэлээр:

Өнгөрсөн 8 дугаар сарын байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 107796,6 мянган төгрөг байна. Нийт шимтгэлийн авлагын 82,1 хувь буюу 530891,9 мянган төгрөгийг аж ахуйн нэгж, байгууллагуудын авлага, 17,9 хувь буюу 735957,2 мянган төгрөгийг төсөвт байгууллагууд эзэлж байна. Нийт авлагын 39,8 хувийг 121 ба түүнээс дээш хоногтой хуримтлагдсан авлагын дүн эзэлж байна.

Долоо. Ажилгүйдлийн даатгалын сангаас ажил олгогчдод дэмжлэг үзүүлэх талаар:

Дэлхий нийтийн хамарсан аюулт цар тахал Коронавируст халдварын нөхцөл байдлын улмаас орлого нь 50 буюу түүнээс дээш хувиар буурсан ажил олгогч байгууллагад ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулахтай холбоотойгоор ажилгүйдлийн даатгалын сангаас 69 ажил олгогч байгууллагын 1312 даатгуулагчид 26240,0 мянга төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн.

Найм.Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын мэдээлэл:

Дэлхий нийтийн хамарсан аюулт цар тахал Коронавируст халдвар (Covid-19) гарсантай холбогдуулан иргэдийг олноор цуглуулахгүй байх шийдвэр гарсантай холбогдуулан Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс цахимаар 4 удаа хуралдаж, 281 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөр зохицуулалтын асуудлыг шийдвэрлэснээс 40 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалсан, 190 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг сунгасан, 51 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шинээр тогтоосон байна.

Цуцлагдсан 40 иргэний 25 нь өндөр насны тэтгэвэр тогтоолсон, 9 нь заалтын хугацаа дууссан, 6 нь эмчлэн эрүүлжсэн иргэд байна.

**Тав. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар**

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ:

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө, мэдээллээр хангах үйлчилгээ:

Ажил хайгч, ажил олоход хүндрэлтэй, ажилгүйдэлд өртөж болзошгүй, их, дээд болон мэргэжлийн боловсролын сургууль төгссөн 23 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө өгснөөс хөдөлмөрт бэлтгэх зөвлөгөөг 18 иргэн, хөдөлмөр эрхлэлтийн талаар 5 иргэнд зөвлөгөө өгөөд байна.

Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэний мэдээ:

Нийт 64 аж ахуй нэгж, байгууллага, иргэнээс 747 сул чөлөөтэй ажлын байрны захиалга ирүүлсний дагуу “Дорнод ажлын байр” хуудас болон хэвлэмэл хуудсаар иргэдэд санал болгож, 616 иргэнийг ажлын байранд зуучлаад байна.

Бүртгэлтэй ажил хайгч, ажилгүй иргэний хөдөлгөөний мэдээ:

Өнгөрсөн сард 1616 ажил хайгч иргэн, үүнээс 757 эмэгтэй бүртгэлтэй байна. Үүнээс 51 хувийг бүрэн дунд боловсролтой иргэд, 17 хувийг тусгай, техникийн боловсролтой иргэд, 16 хувийг дээд боловсролтой иргэд, 7 хувийг суурь боловсролтой иргэд тус тус эзэлж байна.

Шинэ ажлын байр:

Хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй 1616 иргэнээс түр болон улирлын ажлын байранд 70 иргэн, байнгын шинэ ажлын байранд 148 иргэн тус тус зуучлагдсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр:

Ажлын байрны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр:

Тус хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг 4 иргэнд 19,0 сая төгрөг, түрээсийн хөнгөлөлт 2400,0 мянган төгрөгийг 2 иргэнд тус тус олгоод байна.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр:

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд “Гарааны бизнесийг дэмжих Start-up” төвийг шинээр байгуулахад шаардлагатай тохижилт, тоног төхөөрөмжийн төсвийг 2020 оны төсөвт тусгуулсан бөгөөд уг арга хэмжээг орон нутгийн болон төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах журмын дагуу тендэр зарлаж, зохион байгуулснаар засварын ажлыг “Билэгт” ХХК гүйцэтгэж байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх сургалтад хамрагдсан сумын хөдөлмөр, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд төсөл

хөтөлбөрийн санхүүжилт, баримт бичгийн бүрдэл, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд гарч алдаа дутагдал зэргээр мэдээлэл хийж, арга зүйн зөвлөгөө өгөв.

Нийгмийн халамжийн чиглэлээр:

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 1797 иргэн хамрагдаж 495,9 сая төгрөг, асаргааны тэтгэмжид 1368 иргэнд 121,8 сая төгрөг, онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих тэтгэмжид 1229 иргэнд 130,6 сая төгрөг, эх олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг эхийн тэтгэмжид 5077 иргэнд 240,6 сая төгрөг, ахмад настанд олгох тусламж, хөнгөлөлтөд 634 иргэнд 85,5 сая төгрөг, алдар цолтой ахмад настны нэмэгдэл, хөнгөлөлтөд 29 ахмад настанд 4,3 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох тусламж, хөнгөлөлтөд 245 иргэнд 9,6 сая төгрөгийг тус тус зарцуулсан.

Өрхийн мэдээллийн нэгдсэн сан, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ, хүүхдийн мөнгөний талаар:

Өнгөрсөн сард хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг 14 сумын 2348 өрхийн 6992 том хүн, 6164 хүүхдэд нийт 13156 хүнд хүргэж 322,368.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Хүүхдийн мөнгөн тэтгэмж, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээтэй холбоотойгоор эрүүл ахуйн дэглэмийн чанд сахин маск, бээлий өмсч 40 өрхөөр зочлон судалгааг хийсэн.

Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаанд хамрагдаж тулгалтаар мэдээлэл зөрүүтэй гарсан 126 өрх аймгийн хэмжээнд байна. Үүнээс Хэрлэн сумын 73 өрхтэй утсаар холбогдож, холбогдох баримтыг авчран зөрүүг завсарлуулах талаар мэдээлэл өгсөн.

Мэдээллийн зөрүүг холбогдох баримтаар завсарлуулсан 20 өрхийн оноог бодуулахаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлж оноог бодуулсан.

Өрхийн нэгдсэн мэдээллийн санд 2020 оны 8 дугаар сард 141 өргөдөл гомдол, ирснээс 42 өргөдөл нь судалгаанд хамрагдах, 99 өргөдөл нь хүүхдийн мөнгө болон Иргэний эрүүл мэнд даатгалын үйлчилгээний төлбөрөөс чөлөөлөгдөх, Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцаа хүссэн иргэн гаргасан байна.

Хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамрагдахаар хүсэлт гаргаж байгаа өрх иргэний өргөдлийг өргөдлийн цэсэд бүртгэж байгаа эсэх, цаасан өргөдлийн бүртгэлийн огноо цахим өргөдлийн огноотой таарч байгаа эсэхийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын удирдамжийн 66 өрхийн хүүхдийн мэдээллийг хянаж шалгасан. Шалгалтад шаардлагатай бичиг баримт өргөдлийг гаргаж мэдээллээр хангасан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний чиглэлээр:

“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс” энэ сард 1 удаа хуралдаж, 20 хүүхдийн асуудлыг хэлэлцэн 3 хүүхдийн байнгын асаргааг шинээр тогтоож, 1 хүүхдийн байнгын асаргааг

цуцалж, 16 хүүхдийн байнгын асаргааг сунгав. Мөн 5 хүүхдийг эрүүл мэндийн үйлчилгээнд, 19 хүүхдийг нийгмийн хамгааллын үйлчилгээнд холбон зуучилсан.

Азийн хөгжлийн банк, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хамтран хэрэгжүүлж буй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв” баригдахтай холбогдуулан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс болон Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын гишүүдээс асуумж, судалгаа авч хүргүүлэв. Мөн тус төслийн хүрээнд төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн талаарх хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сэтгэл ханамж”-ийн судалгааг хөгжлийн бэрхшээлтэй 40 иргэн, асран хамгаалагчаас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Судалгааны төвөөс баг ирж авсан.

Нийгмийн халамжид хамрагдах иргэний хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авах, шийдвэрлэх журмын хүрээнд:

Засгийн газрын 2020 оны 194 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийгмийн халамжид хамрагдах иргэний хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авах, шийдвэрлэх журам”-ын дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас ehalamj.mn Халамжийн нэгдсэн системийн сургалтыг 2020 оны 08 дугаар сарын 27-ны өдөр цахимаар хэлбэрээр зохион байгуулсан.

Сургалтад нийгмийн халамжийн хэлтсийн мэргэжилтнүүд болон сумдын хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг бүрэн хамруулсан. Иргэд 2020 оны 9 дүгээр сараас эхлэн жирэмсэн эхийн тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж, ихэр хүүхдийн тэтгэмж, 0-18 хүртэлх насны 3 болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт олгох тэтгэмж, “Эхийн алдар” одонтой эхийн мөнгөн тусламж зэрэг тэтгэмжүүдийн хүсэлтийг цахим хэлбэрээр гаргана.

***Зургаа. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
Эрүүл мэндийн газар:***

Магадлан итгэмжлэлийн хугацаа дууссан 2 өрхийн эрүүл мэндийн төв, 2 сумын эрүүл мэндийн төвд Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс томилогдсон 3 шинжээчийн хамт магадлан итгэмжлэлийн шинэ шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт үнэлгээг хийсэн ба урьдчилсан байдлаар хангалттай үнэлгээтэй дүгнэгдсэн.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/02 дугаар захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор алслагдсан хөдөө, орон нутгийн хүн амд 7-8 чиглэлээр төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх “Хөдөлгөөнт эмнэлэг”-ийн баг 8 дугаар сараас эхлэн 6 суманд 3010 орчим хүнд тусламж, үйлчилгээ үзүүлээд байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/05 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2020 оны 8 дугаар сарын 19-28-ны өдрүүдэд “Халдварт сүрьеэ өвчлөлийг бууруулах” төслийн хүрээнд Баян-Уул, Дашбалбар, Гурванзагал, Цагаан-Овоо сумдын зорилтот бүлгийн иргэдэд сүрьеэгийн эрт илрүүлэг үзлэг, эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулсан.

“Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний тухай” аймгийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангах нээлттэй хэлэлцүүлгийг 2020 оны 8 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулж, хэлэлцүүлэгт аймгийн Засаг дарга, Хэрлэн сумын Засаг даргын орлогч, аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Эрүүл мэндийн газрын дарга, мэргэжилтнүүд, Хэрлэн сумын 11 багийн Засаг дарга, сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч, эмч нар, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн холбогдох эмч мэргэжилтнүүд, өрх сумын Эрүүл мэндийн төвийн дарга нар, аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсрол, соёл, урлагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн болон иргэдийн төлөөллүүд оролцсон.

“Глобал” сан, Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбоотой хамтран 2020 оны 8 дугаар сарын 28-31-ний өдрүүдэд Цагаан-Овоо сумын “Степ голд” ХХК-ийн уурхайчдад сүрьеэгийн идэвхтэй илрүүлэг үзлэгийг зохион байгуулсан.

Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд захиалгын дагуу вакциныг олгосон.

Тархвар судлалын заалтаар хийх томуугийн дархлаажуулалтыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд 2-18 нас, жирэмсэн, архаг хууч өвчтэй, 60 дээш ахмад настан, эмнэлгийн ажиллагсдын судалгааг анхан шатны нэгжүүдээс нэрсээр нь гаргуулж мэдээллийг нэгтгэсэн.

Улсын Онцгой комиссын 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн Засаг даргын 2020 оны А/439 дүгээр захирамжийн дагуу ажлын хэсэг томилогдож, аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн газраас тухайн чиг үүргийн дагуу Боловсрол соёл урлагийн газартай хамтран аймгийн сургууль, цэцэрлэгийн захирал, багш ажилчин, эмч, дотуур байрны тогооч, албан хаагч нийт 115 хүнд “Коронавируст (COVID-19) халдварын сэргийлэлт, хяналт, эмнэл зүйн менежмент” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Мөн Хөлөнбуйр, Булган, Баянтүмэн сумын ерөнхий боловсролын бага сургууль, сумын цэцэрлэгт аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Мэргэжлийн хяналтын газар, Боловсрол соёл урлагын газрын 2 мэргэжилтэнтэй хамтран мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

2020-2021 оны хичээлийн шинэ жилийн Хичээл сургалтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө дараахь бэлтгэлийг хангасан. Сургууль орчмын бүс, сургалтын байр, анги танхимд цэвэрлэгээ хийж, мэргэжлийн байгууллагаар халдваргүйжүүлэлт хийгдсэн. Хичээл сургалтын үйл ажиллагааны явцад багш, ажилтан, оюутан, суралцагч, цэцэрлэгийн болон дотуур байрны хүүхдээс сэжигтэй тохиолдол илэрсэн

үед тусгаарлах байрыг бэлэн байлгуулах талаар зөвлөгөө өгсөн. Анги танхимд сандал хоорондын зайг 1,5 метр байхаар, нэг анги, бүлэгт хичээллэх хүүхдийн тоо 20±5 байхаар тооцож бэлтгүүлсэн. Эрүүл мэндийн яам болон холбогдох мэргэжлийн байгууллагаас гаргасан халдвараас урьдчилан сэргийлэх санамж, зөвлөмжийг анги, танхимд хангалттай хэмжээгээр байршуулахыг зөвлөсөн. Анги, танхимд 2 цаг тутамд байгалийн болон механик агааржуулалт хийх нөхцөл боломжийг бүрдүүлсэн байна. Анги танхимд хүүхдүүдийг орж гарах үед биеийн халууныг үзэж тэмдэглэж байх. Коронавируст халдвар (КОВИД 19)-аас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах чиглэлээр багш, ажилтныг сургалтад бүрэн хамруулсан байна.

НҮБ-ын Хүн амын сангаас Нэг цэгийн үйлчилгээний төвд үйлчлүүлж буй иргэдэд шинэ төрлийн коронавирус “Ковид 19” цар тахлын үед хэрэглэх зорилго бүхий ариун цэврийн багцуудыг хүлээлгэн өгсөн.

Гэр бүл цуцлалт, хүүхдийн асран хамгаалал тогтоох асуудлаар шүүх байгууллагаас ирүүлсэн шүүгчийн захирамжийн дагуу шинжээчийн дүгнэлт гаргах асуудлаар Хэрлэн болон Цагаан-Овоо суманд асуудал хариуцсан мэргэжилтнүүд очиж ажилласан.

Гэр бүлийн асуудлаар 7 хүнд сэтгэл зүйн зөвлөгөө өгч, 4 хүнд сэтгэл зүйн оношилгоо хийсэн.

Залуучуудын хөгжил оролцооны чиглэлээр:

Залуучууд хөгжлийн төвөөс “Амьдрах ухааны чадвар олгох” 12 модуль сургалтыг цувралаар өсвөр үе, залуучуудад тогтмол зохион байгуулж байна. Тайлант сард Нэг цэгийн үйлчилгээний төвөө үйлчлүүлж буй хүүхдүүд, аж ахуй үйлчилгээнд ажиллаж, хорих ял эдэлж байгаа, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүүхдүүд, аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Цагдаагийн газрын эрүүлжүүлэх, саатуулах байрны баривчлах байранд хүмүүжиж байгаа нийт 56 хүүхэд залуучуудад “Ялгаатай байдал”, “Хорт зуршил”, “Харилцаа хандлага”, “Өөртөө итгэх итгэл”, “Сэтгэлийн хөдөлгөөнөө хянах”, “Стрессийг зохицуулах нь”, “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга”, “Холбоо тогтоох чадвар” зэрэг сэдвүүдээр сургалтыг зохион байгуулав.

Бусдын туслалцаагүйгээр өдөр тутмын үйлдлээ бие даан гүйцэтгэх чадваргүй байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй 5 залуучуудад “Хүрч очих үйлчилгээ”-г үзүүлж, амьдрах ухааны чадвар олгох, хувь хүний хөгжлийг дэмжих цуврал сургалтыг хүргэн ажилласан.

“Анна хоуме асрамж, халамжийн төвийн өсвөр үе, залуучуудын хөгжил, оролцоог дэмжих зорилгоор өөрсдийн хүсэл, сонирхлын дагуу 2 залууг Төгөлдөр хуурын сургалтад үнэ төлбөргүй хамруулж, дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Дөрөв. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
Нийгмийн даатгалын хэлтэс

1. Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлтийн талаар:

Нийгмийн даатгалын санд 2020 оны 7 дугаар сард 2163094.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 1830071.5 мянган төгрөг төвлөрүүлэн төлөвлөгөөг 84,6 хувиар биелүүлсэн байна. 2020 оны 07 дугаар сарын мэдээгээр нийгмийн даатгалын сангийн орлогын биелэлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1

Нийгмийг даатгалыг сангийн орлого /мянган төгрөг/

д/д	Төрөл	Төлөвлөгөө	Биелэлт	Хувь
1	Тэтгэврийн даатгалын санд	703878,6	1175737,65	167,0
2	Тэтгэмжийн даатгалын санд	65018,7	132067,15	203,1
3	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын санд	49217,7	128320,91	260,7
4	Ажилгүйдлийн даатгалын санд	10324,5	28436,7	275,4
5	Эрүүл мэндийн даатгалын сан	1334654,5	365509.13	232,0
	Нийт	2163094.0	1830071.5	84,6

2020 оны 07 дугаар сард нийт 648 ажил олгогч байгууллагын 4755 даатгуулагчийн 256490.0 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлээс(ЭМД-ын шимтгэлээс бусад) чөлөөлсөн.

Түүнчлэн 3940 сайн дурын даатгуулагчдын 836041.5 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлээс тус тус чөлөөлсөн байна.

2. Тэтгэвэр тогтоолт, олголтын талаар:

Аймгийн хэмжээнд 2020 оны 07 дугаар сард шинээр нийт 103 иргэнд тэтгэвэр тогтоосон. Үүнээс:

Өндөр насны тэтгэвэр 77, (малчин 13, хүүхдээр 22, хүнд нөхцлөөр 4, цэргийн алба хаасны тэтгэвэр 2, хэвийн ӨН 36)

Тахир дутуугийн тэтгэвэр 21,

Тэжээгч алдсны тэтгэвэр 5 тус тус тогтоолоо.

Түүнчлэн 2020 оны 06 дугаар сард нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалын сангаас нийтдээ:

Өндөр нас 8900

Тахир дутуу 2765,

Тэжээгчээ алдсан 610

Цэргийн тэтгэвэр 599 нийт 12874 тэтгэвэр авагчдад 4996284,03 мянган төгрөгийн тэтгэвэр олгосон.

3. Тэтгэмж олголтын талаар:

Тэтгэмжийн даатгалын сангаас :

Хөдөлмөрийн чадвар түр алдсны тэтгэмж 151,

Жирэмсэн амаржсны тэтгэмж 139,

Оршуулгын тэтгэмж 29 даатгуулагчид, нийт 511936,8 мянган төгрөгийн тэтгэмжийг тус тус олгосон.

4. Ажилгүйдлийн тэтгэмж олголтын талаар:

Аймгийн хэмжээнд 2020 оны 7 дугаар сард нийт 81 даатгуулагчдад 40,8 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг бодож олгов. Энэ нь өмнөх сартай харьцуулахад 6 даатгуулагчийн 5 сая төгрөгөөр ажилгүйдлийн даатгалын зардал буурсан үзүүлэлттэй байна.

5. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн зардал:

Уг сангаас нийт 94 тэтгэвэр авагчдад 140526,7 мянган төгрөгийн тэтгэвэр олгосон байна. Рашаан сувиллын зардал 1 даатгуулагчид 332,0 мянган төгрөгийг олгосон.

6. Нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлагын чиглэлээр:

2020 оны 07 дугаар сарын байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 647072.2 мянган төгрөг байна. Нийт шимтгэлийн авлагын 82,1 хувь буюу 530891.9 мянган төгрөгийг аж ахуйн нэгж байгууллагуудын авлага, 17,9 хувь буюу 116180.3 мянган төгрөгийг төсөвт байгууллагууд эзэлж байна. Нийт авлагын 39,8 хувийг 121 ба түүнээс дээш хоногтой хуримтлагдсан авлагын дүн эзэлж байна.

7. Ажилгүйдлийн даатгалын сангаас ажил олгогчдод дэмжлэг үзүүлэх талаар:

Цар тахлын улмаас орлого нь 50 буюу түүнээс дээш хувиар буурсан ажил олгогч байгууллагад ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулахтай холбоотойгоор ажилгүйдлийн даатгалын сангаас 69 ажил олгогч байгууллагын 1312 даатгуулагчид 26240,0 мянга төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн.

8.Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс:

Шинэ коронавируст халдвар (Covid 19) цар тахлын нөхцөл байдлын улмаас иргэдийг олноор цуглуулахгүй байх шийдвэр гарсантай холбогдуулан Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс цахим хурлаар 4 удаа хуралдаж, 281 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөр зохицуулалтын асуудлыг шийдвэрлэснээс 40 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалсан, 190 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг сунгасан, 51 даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шинээр тогтоосон байна.

Цуцлагдсан 40 иргэний 25 нь өндөр насны тэтгэвэр тогтоолсон, 9 нь заалтын хугацаа дууссан, 6 нь эмчлэн эрүүлжсэн иргэд байна.

Зургаа. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР

/COVID 19/ халдвараас урьдчилан сэргийлэх талаар ажил: 0-12 насны хүүхэдтэй эхчүүдэд цалинтай чөлөө олгох хугацааг сунгах тухай аймгийн Засаг даргын 2020 оны А/218 дугаар захирамжийн хүрээнд тус байгууллагын 0-12 настай 5 эмэгтэй албан хаагч байгаагаас чөлөө авсан албан хаагч байхгүй өөрсдийнх нь хүсэлтээр ажлын цагийг богиносгож ажиллах боломжоор ханган ажиллаж байна.

МАЛ АЖ АХУЙ:

Өвс, тэжээлийн, агуулах, саравч шинээр барих ажилд хяналтаар ажилсан тухай:

Орон нутгийн төсөв болон “Зах зээл бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн 330 сая төгрөгийн санхүүжилтээр Халхгол, Сэргэлэн, Хэрлэн сумдад аюулгүйн нөөцийн өвс тэжээлийн агуулах, саравч барих ажлын явцад газрын даргын баталсан ажлын хэсэг хяналт тавьж ажиллалаа.

Сэргэлэн, Хэрлэн сумын өвс тэжээлийн аюулгүйн нөөцийн агуулах, саравч барих ажлыг “Смартлифт” ХХК, Халхгол сумын өвс тэжээлийн аюулгүйн нөөцийн агуулах барих ажлыг “Ар өвөр эрэн” ХХК тус тус хийж гүйцэтгэж байна.

Өвс тэжээлийн агуулах, саравч барих ажилд хяналт тавьж ажиллахад дараах нийтлэг зөрчил тутагдал илэрсэн байна. Үүнд:

1. Ажлыг гүйцэтгэхдээ далд хийсэн ажлыг зургаар бүрэн баталгаажуулаагүй
2. Борооны усны хаялгын цутгалын хөрсийг нягтруулаагүй
3. “Ар өвөр эрэн” ХХК-ий Халхгол суманд гүйцэтгэж байгаа тэжээлийн агуулахын багнан суурийг хийгээгүй байж шалны цутгалт хийсэн
4. “Ар өвөр эрэн” ХХК-ий Халхгол суманд гүйцэтгэж байгаа өвсний саравчны баганыг модоор хийхийг зохиогчоос зөвшөөрөл авалгүй төмөрөөр сольж хийсэн
5. Өвсний саравчны суурийг цутгахдаа дүүргэлтийг стандартын бус тоосгоор дүүргэсэн гэх мэт зөрчлүүд илэрсэн.

Ажлын хэсэг өвс тэжээлийн агуулах барих ажлын явцаж хяналт тавьж дээрх гарсан зөрчил дутагдлыг засаж сайжруулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Сэргэлэн, Халхгол сумын өвс, тэжээлийн агуулах барих ажил 50-55 хувийн гүйцэтгэлтэй, Хэрлэн сумын өвс тэжээлийн агуулах 100 хувь гүйцэтгэж ажлаа хүлээлгэн өгөх талаар албан бичиг ирүүлээд байна.

“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл”-өөр хийгдэж байгаа ажлын хяналт: Орон нутгийн төсөв болон “Зах зээл бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн 110 сая төгрөгийн санхүүжилтээр Сэргэлэн суманд аюулгүйн нөөцийн өвс тэжээлийн агуулах, саравч барих ажлын явцад, 2019, 2020 онд гаргасан инженерийн хийцтэй худаг, 2019, 2020 онд хийсэн бог мал угааврын ваннын ашиглалт болон явцын хяналтыг Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн зохицуулагч С.Занданбал, мэргэжилтэн Оюунтуяа, аймгийн төслийн зохицуулагч О.Одончимэг, мал эмнэлэгийн газрын дарга Ч.Аюушмаа, Хүнс, хөдөө аж ахуйн газрын Бэлчээр, тэжээл усан хангамж хариуцсан мэргэжилтэн Ч.Шинэцэцэг нар 08 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд газар дээр танилцлаа.

Өвс тэжээлийн агуулах, саравч: Сэргэлэн сумын өвс тэжээлийн аюулгүйн нөөцийн агуулах, саравч барих ажлыг “Смартлифт” ХХКомпани 70-75 хувийн гүйцэтгэлтэй хийж байна. Ажил гүйцэтгэлийг хугацаанд нь чанартай өгөхийг үүрэг болголоо.

Инженерийн хийцтэй худаг: 2019 онд Сэргэлэн сумын 2-р багийн Дэлийн зүүн үзүүрт гаргасан худгийн хаалга салж унасан, цонх байхгүй зэрэг ашиглалт муу байгаа тул эзэмшигч иргэнийг сольж ашиглалт, хамгаалалтыг сайжруулж ажиллахыг сумын удирдлагад мэдэгдлээ. Сэргэлэн, Булган, Хөлөнбуйр суманд 2019, 2020 онд гаргасан инженерийн хийцтэй худгийн усны ундарга, ашиглалт, хамгаалалт сайн байна.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын А/15 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Орон нутгийн Хөгжлийн сан, “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн санхүүжилтээр Баянтүмэн, Сэргэлэн сумдад Сатабу ХХК-ын гүйцэтгэж байгаа инженерийн хийцтэй гүн өрмийн худаг гаргах ажлын явцад хяналтыг хийж ажилласан.

Баянтүмэн сумын Өлзийт багийн худаг Төхөм гэдэг газар угаж байгаа худаг одоо 15м гүн өрөмдөж байгаа нь

Сэргэлэн сумын Очир хүрээ багийн Муруй хоолой гэдэг газар ухаж байгаа худаг одоо 10 м гүн өрөмдөж байгаа нь

Инженерийн хийцтэй гүн өрмийн худаг шинээр барьж байгуулах 2020-А/165-07 дугаар гэрээний дагуу тендерийн баримт бичиг, батлагдсан зураг төсвийн дагуу төсөвт өртөгт багтаан барьж байгаа эсхэд газар дээр нь очиж хяналтыг тавихад гарсан ямар нэг зөрчил байхгүй байна.

Бог мал угааврын ванн: Сэргэлэн суманд 2019 онд баригдсан бог мал угааврын ванн нь ашиглалтанд ороод 10000 гаруй мал угаагдаж байна. Мал угаахад ванны ус хийх гүн багадаж байна гэсэн санал гарч байна. Сэргэлэн, Баянтүмэн, Хөлөнбуйр суманд 2019, 2020 онд “Жорон” ХХКомпаны гүйцэтгэсэн мал угааврын ванны цементийн цутгалт муу, зөөврийн хашааны урт дутуу, холболтыг гагнагдан байдал муу зэрэг дутагдлыг засаж сайжруулахаар үүрэг болгон ажиллаа.

Сэргэлэн, Гурванзагал, Дашбалбар суманд 2020 онд “Смартлифт” ХХКомпаны гүйцэтгэсэн бог мал угааврын ванны гүйцэтгэл сайн байна.

Хадлан бэлтгэл: Аймгийн хэмжээнд 12 сумын 113,3 мянга га газар хадлан бэлтгэхээр сумын ИТХ-ын тогтоолоор баталсан байна. Аймгийн ИТХ-аар баталсан “Бэлчээр, хадлан, тэжээлийн талаар баримтлах бодлого”-ын 5.2.11 дэх заалтын хүрээнд Баяндун, Хөлөнбуйр, Матад, Халхгол сумдууд үйлдвэрлэлийн зориулалтаар хадлангийн газрын зөвшилцөх хүсэлтээ ирүүлсэн. Сумдууд үйлдвэрлэлийн зориулалттай хадлангийн газрыг иргэн, аж ахуй нэгжид хувиарлаж олгох ажлыг хийж байна.

ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Сургалтад хамрагдсан тухай: Хэнтий аймагт 8-р сарын 17-20-нд зохион байгуулагдсан хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан мах бэлтгэх, олон улсын стандартыг нэвтрүүлэх аргачлалын талаар мэдлэг, ур чадвар олгох “Мах, махан бүтээгдэхүүний мал эмнэлэг - ариун цэврийн нөхцөл” сэдэвт бүсчилсэн сургалтад 4 аймгийн мал төхөөрөх, мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийн технологич, малын эмч, мал эмнэлгийн хяналтын байцаагч нар, Хүнс, хөдөө аж ахуйн газрын хүнсний үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтнүүд хамрагдсан. Дорнод аймгаас 12 албан хаагч, аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцсон. Сургалтаар мал төхөөрөх, мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийн ариун цэврийн дадлын дүрэм, малд байх ёсгүй халдварт өвчин, тэдгээрийг таних, оношлох аргачлал, гулууз мах, дотор, дайвар эрхтэнг хөргөх, хөлдөөх, хадгалах технологи, эрхтэн систем, их биеийн тунгалагийн зангилааг шинжлэх, зүсэлт хийх арга ажиллагаа, үнэлэх зарчмын онол практикийн сургалтыг явуулсан. Сургалтыг Мал эмнэлгийн ерөнхий газар, НҮБ-ын ХХААБ-ын “Монгол Улсад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”, Азийн хөгжлийн банкны “Хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг дэмжих техник туслалцааны төсөл” хамтран зохион байгуулсан.

Сургалт зохион байгуулах: 2020-2021 оны хичээлийн жилийн бэлтгэлийг хангах, Ерөнхий боловсролын сургуулийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээний хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилготой “2020-2021 оны хичээлийн жилийн бэлтгэл ажилд анхаарах асуудал” сэдэвт сургалтыг Боловсрол, соёл урлагийн газраас 2020 оны 8 дугаар сар 27, 28-ны өдөр зохион байгуулах гэж байна. Тус сургалтад аймгийн сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн 32 эмч, 64 ахлах тогооч, дотуур байрны 16 багш нар оролцоно. Хүнс, хөдөө аж ахуйн газрын зүгээс “Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд

хэрэглэх дотоодын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний жагсаалт”-ыг танилцуулж мэдээлэл өгөх юм.

ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Монгол улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 113 тоот тогтоолоор батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу урьдчилсан судалгааг хийж дууссан тул 11.5.3 буюу нарийвчилсан судалгааг хийхээр жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн мэргэжилтнүүд Дорнод аймагт ажиллаж, 21 төсөлтэй газар дээр нь танилцаж, үнэлэлт дүгнэлт хийлээ.

ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Нийт эргэлтийн талбай (га-аар)	Тариалсан талбай (га-аар)	Боловсруулах уриншийн захиалга (га-аар)	Эргэлтэнд орох талбай (га-аар)	Талбайн Ашиглалт (хувиар)
93266	35083	35280	70363	75.4

Энэ онд аймгийн хэмжээнд ХХААХҮ-ийн сайд, Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээгээр 22.6 мянган га-д үр тариа, үүнээс 18.5 мянган га-д улаан буудай, 4.5 мянган га-д тосны ургамал, 2.5 мянган га-д малын тэжээл 161 га-д төмс, 117 га-д хүнсний ногоо тариалж, үр тарианы ургац 27.0 мянган тн, үүнээс 22,2 мянган тн улаан буудай, 4.8 мянган тн бусад үр тариа, 3.6 мянган тн тосны ургамал, 1.9 мянган тн төмс, 1.4 мянган тн хүнсний ногооны ургац хураан авахаар төлөвлөөд байна. нийт 93.2 мянган га эргэлтийн талбайн 35.0 мянган га-д тариалалт, 35.2 мянган га-д уриншийн боловсруулалт хийхээр төлөвлөж 70.2 мянган га буюу 75.4 хувь эргэлтэд оруулаад байна.

2020 оны 06 сарын 25-ны байдлаар 35.0 мянган га-д тариалалт хийгдэж үүний 61 хувь нь улаан буудайн тариалалт эзэлж нийт тариалалтын төлөвлөгөөг 17.4 хувь

ДОРНОД АЙМГИЙН ТАРИАЛАЛТЫН МЭДЭЭ	2020 оны төлөвлөгөө	Нийт үр тариа (га-аар)	Тарьмлын төрлөөр								Нийт тариалах талбай (га-аар)
			Үр тариа таримлын төрлөөр (га-аар)				Бусад тарьмал (га-аар)				
			Буудай	Арвай	Овьёос	Бусад үр тариа	Тосны ургамал	Малын тэжээл	Төмс	Хүнсний ногоо	
Тариалах төлөвлөгөө (га-аар)	22600	18500	300	300	3500	4500	2500	161	117	29878	
Тариалсан талбайн хэмжээ (га-аар)	28127	21411	50	2875	3791	1968	4718	159	111.3	35083	
Төлөвлөлтийн гүйцэтгэл	124.5	115.7	16.7	958	108.3	43.7	188.7	98.5	95.1	117.4	
Тариалсан талбайд тарьмлын эзлэх хувь	80.2	61.0	0.1	8.2	10.8	5.6	13.4	0.5	0.3	100	

давуулан биелүүлээд байна.

Тариалалтын хувь: Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 07 дугаар хуралдааны 09 тогтоолоор батлагдсан Таримлыг тариалангийн талбайн сэлгээнд тариалах тухай тогтоолын хүрээнд нийт тариалсан талбайн 80.2 хувь үр тариа, үүний 61 хувь улаан буудай, 5.6 хувь тосны ургамал, 13.4 хувь малын тэжээл, 0.8 хувь төмс, хүнсний ногоо тус тус эзэлж байна.

Хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих зорилгоор Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Эртийн ургац-2020" үзэсгэлэн худалдаа Дорнод худалдаа ХХК-ны Шүр зах дээр 8 дугаар сарын 1-нээс 7 хоног Аймгийн ногоочдын холбоо ТББ хамтран амжилттай зохион байгуулав. Арга хэмжээнд Хэрлэн, Баянтүмэн сумдын 12 ногоочин 11 төрлийн хүнсний ногоогоор оролцсон.

ХХААХҮЯамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 08 сарын 10 өдрийн 01/2739 албан тоотоор өгсөн чиг үүргийн хүрээнд 2020 онд хураан авах ургацын урьдчилсан төлөв байдлыг тариалангийн бүс нутагт үйл ажиллагаа явуулдаг үр тарианы аж ахуйн нэгжүүдийн талбайд ажиллах талаар Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2020 оны 08 сарын 17 өдөр баталсан удирдамжийн дагуу 2020 оны 08 дугаар сарын 18-21 өдрүүдэд Баян-Уул, Баяндун, Дашбалбар, Чойбалсан, Баянтүмэн, Халх гол сумдын үр тарианы аж ахуйн нэгжүүд тариа бригадуудад ажиллаа.

Урьдчилсан балансар: Улаан буудай 21411 га-аас 1000 га тэжээлд шилжиж 20411 га-аас 14,6 цн буюу 29800 тн ургац хураан авна.

Төмс 179,9 га-аас 112,5 цн буюу 2023,8 тн, хүнсний ногоо 120,5 га-аас 95 цн буюу 114,7 тн ургац хураан авах төлөвлөгөөг гаргаж ажиллаа.

Улаан буудайн тариалалт							Буудайн хуваарилалт					
Тарьсан талбай /га-аар/	Ургац алдсан талбай /га-аар/	Үүнээс		Тэжээлд шилжсэн /га/	Хураах талбай /га-аар/	Нэжгийн ургац цн-ээр	Бүх ургац /тн-оор/	Өөрийн үрэнд /тн/	Урийн нөөцөд /тн/	Тэжээлд /тн/	Спиртийн үйлдвэрт /тн/	Гурил үйлдвэрлэлд /тн/
		Ганд нэрвэгдсэн	Мөндөрт цохигдсон									
21411	0			1000	20411	14.6	29800	4500	3500	800	500	20500

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн Сайдын 2020 оны А/153 дугаар тушаалаар сум дундын отрын бүс нутгийн бэлчээрийн судалгаа хийх, бэлчээрийн хэв шинжийг тодорхойлох, отрын бэлчээрийн хилийн заагийг баталгаажуулж газрын нэгдмэл сангийн мэдээллийн санд оруулах, тухайн орон нутгийн тусгай хэрэгцээний

сум дундын отрын бэлчээр ашиглалтын талаар авах арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг баталсан.

Дээрх тушаалын дагуу аймгийн Засаг даргын 2020 оны А/369 дүгээр захирамжаар дээрх ажлыг эрчимжүүлэх зорилгоор холбогдох агентлагуудыг хамруулсан ажлын хэсгийг байгуулсан. Уг захирамжийн дагуу 2020 оны 08 дугаар сарын 11-12-ны өдөр Халхгол сумын Засаг дарга, багийн Засаг дарга нар болон холбогдох мэргэжилтнүүдтэй уулзан сум дундын отрын нөөц бэлчээр байгуулах газрын саналыг аван ажилласан.

Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүнс, Хөдөө аж ахуйн байгууллага болон Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын хооронд байгуулсан 2019/92 дугаартай хамтран ажиллах гэрээнд заасан Монгол улсаас НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь Конвенцэд хүргүүлдэг Хүлэмжийн хийн тооллогын 2 жил тутмын тайлан, илтгэлд ашиглагдах газар ашиглалт, түүний өөрчлөлтийн мэдээг гаргахад мөрдөх “Газрын нэгдмэл сангийн ангиллыг Олон улсын газрын ангилалд шилжүүлэх” зааврын дагуу тус газраас “Парисын хэлэлцээрийн хүрээнд Монгол улсын оруулах Үндэсний хувь нэмрийн хэрэгжилтийг хөдөө аж ахуй, газар ашиглалтын салбарт ил тод байдлаар тайлагнах, мониторингийн үндэсний чадавхыг бэхжүүлэх” төсөлтэй хамтран “Collect earth програмыг ашиглан газар ашиглалт, газар ашиглалтын өөрчлөлтийг хэрхэн үнэлэх нь” цэгэн торлол үүсгэсэн 5890 цэгийг үнэлэн бүрэн дуусган Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт хүргүүлэн ажилласан.

Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас 2020 оны 08 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан газрын даргын 2020 оны А/131 дүгээр тушаалаар батлагдсан “Газрын мониторингийн системийг ажиллуулах журам”-ын дагуу газрын төлөв байдал чанарын захиалгат хянан баталгааны ажлыг цахим хэлбэрээр хянаж, байнгын шинжээчээр баталгаажуулах цахим сургалтад хамрагдлаа.

Газрын төлбөрийн 2021 оны төсвийн төсөөлөл болон дуудлага худалдааны орлогын гүйцэтгэлийг хавсралт хүснэгтийн дагуу enkh-erdene.e@gazar.gov.mn гэсэн хаягаар 2020 оны 643 тоот албан бичгээр хүргүүлэв.

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.2, 23.8.14 дахь заалтын дагуу хадлангийн газрын төлбөрийг аймгийн төсөвт буюу төрийн сангийн 100070000943 дансанд 60 хувийг, сумын төсөвт 40 хувийг тус тус төвлөрүүлэх талаар сумдын Засаг дарга нарт 2020 оны 642 дугаар албан бичгээр чиглэл өгсөн.

Газрын кадастрын вэб системд Хэрлэн сумын гэр бүлийн хэрэгцээний 369 иргэний тин дугаар татаж нэхэмжлэх үүсгэх төлөвт оруулж, өмчлөлийн бүртгэлийн 1889 иргэний татвар бодуулсан.

Улсын бүртгэлийн хэлтсээс газар өмчлөгчийн хамтран өмчлөгч хассан, бэлэглэсэн, худалдсан, өв залгамжилсан өмчлөгчийн бүртгэлийг сум тус бүрээр авч сумдын газрын даамлуудад засварлах ажлыг хэрхэн хийх талаар зөвлөмж өгсөн.

Газрын кадастрын мэдээллийн санд 65 иргэн аж ахуй нэгжийн кадастрын зургийг мэдээллийн санд оруулж өөрчлөлт хийсэн. Дундын мэдээллийн сангаар дамжуулж 12 иргэн аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг илгээж гэрчилгээ олгож, гэрээ байгуулсан байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Төрийн өмчийн газрыг зурагжуулж бүртгэн Газрын кадастрын мэдээллийн санд оруулж баталгаажуулах ажил”-ыг манай аймагт “Газар дэлхий” ХХК хийж гүйцэтгэсэн болно.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга Х.Гүенбат, мэргэжилтэн Э.Золбоо нар 2020 оны 08 дугаар сарын 13-ны өдөр Дашбалбар суманд томилолтоор ажилласан. “Дашбалбар сумын төвөөс Чух нуурын чиглэлд Цахилгаан дамжуулах агаарын шугам барих ажилд дэмжлэг” ажлыг “Дорсүхэ” ХХК хийж гүйцэтгэж дуусан аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/13 тоот тушаалын дагуу комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад хүлээн авч ажиллалаа.

Мөн тус сумын нутаг дэвсгэрт “Элтрүүд” ХХК-ийн гүйцэтгэж буй “Буриад үндэстний өв соёлын төв” ажлын барилга угсралтын ажилд захиалагчийн хяналт гүйцэтгэлээ. Тус ажлын газар шорооны ажил хийгдэж дууссан ба барилгын баганан суурь цутгах ажил хийгдэж шугаман суурь, суурийн бүс бетон цутгалтын ажил хийгдэж байна.

Барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн Э.Золбоо, мэргэжилтэн Т.Бат-Эрдэнэ нар 2020 оны 08 дугаар сарын 19-ний өдөр Баян-Уул суманд томилолтоор ажилласан. Тус сумын нутаг дэвсгэрт “Бага сургуулийн барилгыг спорт заалтай хүзүүвчээр холбох” ажлыг “Элтрүүд” ХХК хийж гүйцэтгэж дуусан аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/13 тоот тушаалын дагуу комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад хүлээн авч ажиллалаа.

Булган сумын нутаг дэвсгэрт Орон нутгийн хөнжлийн сангийн 66 000 000 төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн “Хүүхдэд ээлтэй орчин” төслийн хүрээнд хөдөөгийн сумын цэцэрлэг, сургуулийг боловсон ариун цэврийн байгууламжтай болгох ажлын 5 дугаар багц /Булган сумын ЕБС-ийн дотуур байр/” ажлыг ашиглалтад оруулах комисс 2020 оны 08 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж ашиглалтад хүлээн авч ажиллаа.

Хэрлэн сумын нутаг дэвсгэрт “Баянлуу” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн “Хүүхдийн тоглоомын болон чийрэгжүүлэлтийн талбай нэмж байгуулах /Хэрлэн сумын 1, 2, 8, 9, 10-р баг/ ажлыг 08 дугаар сарын 24-ний өдөр ашиглалтад хүлээн авч ажиллаа.

Хэрлэн сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил нэмэлт санхүүжилт төслийн хөрөнгөөр “Смарт лифт” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн “Өвс тэжээлийн агуулах, саравч шинээр барих” ажлыг 08 дугаар сарын 28-ны өдөр ашиглалтад хүлээн авч ажиллалаа.

Матад сумын Ерөнхий боловсролын сургуулийн засварын ажилтай танилцлаа. Хяналтын явцад бетон цутгалтын ажил, дотор заслын ажлууд хийгдэж байна. Ажлын талбайд халтирдаггүй шаазан хавтан, дулаалгын хавтан, зүймэл модон шал зэрэг материалууд бүрэн татагдсан байдалтай байна. Барилга угсралтын явц 70%. Хана, хаалга цонхны булан тохой, амлагааг засаж дахин будах, шаазан хавтангийн ажил гүйцэтгэхдээ түвшинг барьж, тэгш байдлыг алдагдуулахгүй байх, будгийн ажил гүйцэтгэхдээ зүлгүүр үе хийх зэрэг үүрэг даалгавар өгөн ажилсан. Гүйцэтгэгч компани тус ажлыг 2020 оны 8-р сарын 24-ний өдөр хүлээлгэн өгөх хүсэлтээ ирүүлсэн боловч 2020 оны 08 дугаар сарын 27-ны өдөр хийсэн хяналт шалгалтын явцад өмнө өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, будаг шаврын ажил шаардлага хангахгүй, шаазан хавтангийн түвшин зөрсөн, гадна фасадны төмөр хавтанг бэхлэхдээ технологийн алдаа гаргасан байсан тул дээрх алдаа дутагдлыг 2020 оны 09 дүгээр сарын 08-ний дотор засаж залруулах албан шаардлага хүргүүлээд байна.. Тус сумын соёлын төвийн барилгын хувьд бетонон хучилтын задлан буулгалтыг дам нуруунаас 50-70см-т хийх зөвлөмж хүргүүлэн ажилласан.

Халхгол суманд баригдаж буй өвс, тэжээлийн агуулахын барилгын ажлын явцтай танилцлаа. Уг ажлыг Ар өвөр эрээн ХХК тендер шалгаруулалтад шалгарсан байна. Барилга угсралтын ажлын явцад дараах зөрчил дутагдал илэрсэн.

Зураг төсөвт тусгагдсан модон эдлэлийг зураг төсөв зохиогчийн зөвшөөрөлгүй сольсон, тэжээлийн агуулахын барилгын баганан суурийн ажил хийгдээгүй орхигдуулсан... зэрэг алдаа дутагдлууд илэрсэн бөгөөд модон эдлэлийг 100мм х 100мм квадрат төмрөөр сольж хийсэн нь чанарын хувьд илүү боловч үүнд зураг төсөв зохиогчоос зөвшөөрөл авч гүйцэтгэлийн зураг гаргуулах үүрэг өгсөн. Тэжээлийн агуулахын баганан суурийн ажлыг хийлгүй шалны цутгалт хийгдсэн байсан бөгөөд баганан суурийг бетон шалыг хэсэгчлэн хуулж дахин цутгах зааварчилгаа өгөн ажилласан. Барилга угсралтын ажил 55%

Хэрлэн сумын 9 дүгээр багт Улсын төсвийн 1 360 000 000 төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн “Бага сургуулийн өргөтгөлийн барилга /Дорнод, Хэрлэн сум, 1 дүгээр сургууль/” ажлыг Дорнод аймгийн Засаг даргын даргын 2020 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн А/426 дугаар захирамжийг үндэслэн 19 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2020 оны 08 сарын 27-ны өдрийн 10 цагт ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж 73/2020 дугаартай акт үйлдэн тус барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн аваад байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

